

ХЭВЛЭЛИЙН ТОВЧОО

Оросын Холбооны Улс ба Монгол Улс нь эртнээс сайн хөршийн харилцаатай билээ. Үүнд мэдээж хоёр орны соёлын харилцаа ч мөн хамаарна. Харамсалтай нь цар тахлын үеэр хоёр улсын хил хаагдсаны улмаас соёл хийгээд эдийн засгийн харилцаа их бага хэмжээгээр хумигдсан билээ. Харин яг одоо хоёр орны соёлын харилцааг ахин сэргээх таатай үе ирсэн гэж үзэж байна. Үүний нэгэн илрэл болгож оросын төлөөлөл анх удаа Улаанбаатар хотноо жил бүр зохион байгуулагддаг “Үндэсний номын баяр”-т оролцож байна.

31 дэх удаагийн “Үндэсний Номын Баяр”-т Алексей Варламов, Максим Амелин, Олег Шишкин, Александр Снегирёв, Амарсана Улзытуев, Анна Банаева зэрэг оросын орчин үеийн уран зохиолын нэртэй зохиолч, яруу найрагч, орчуулагчид оролцоно. Мөн утга зохиолын шүүмжлэгч Константин Мильчин, түүхч соёл судлаач Анна Эспарса болон оросын утга зохиолыг монгол хэлэнд хөрвүүлдэг нэртэй орчуулагчид оролцож байгаа нь монголын уншигчдад нэн сонирхолтой байна гэдэгт итгэлтэй байна.

“Русская юрта” буюу “Орос гэр” нэртэй асар маань гурван өдрийн туршид номын баярт оролцогч хэн бүхнийг найрсагаар угтан авч, урлаг соёлын уулзалт, номын танилцуулга, халуун дотно яриа өрнүүлэх зэргээр та бүхэнтэй уулзахдаа баяртай байх болно. Бид та бүхнийг уран сайхны, хүүхдийн, түүхийн болон нийгэм улс төрийн зэрэг сэдэв бүхий оросын орчин цагийн ном хэвлэлийн шилдэг дээжтэй танилцуулахаар бэлдэж байна. Мөн LED дэлгэцээр оросын утга зохиол, соёлын тухай видео бичлэгийг үзэж, номын баярт оролцож буй зохиолчдын шилмэл бүтээлүүдийн танилцуулгыг мөн хүлээн авах боломжтой. “Үндэсний Номын Баяр”-ын өмнө, хүрэлцэн ирсэн оросын зохиолчид маань Монголын Зохиолчдын Эвлэл, Монголын Орчуулагчдын Эвлэл зэрэг байгууллагуудын үзэг нэгт нөхөдтэйгөө уулзалт хийхээр төлөвлөж байна.

“Орос гэр” асрын нээлтэнд Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Искандер Азизов оролцох бөгөөд, үзэсгэлэн эхлэхээс дуусах хүртэл, бид та бүхнийг огтхон ч уйдаахгүй олон сонирхолтой үйл ажиллагаануудыг тасралгүй зохион байгуулахаар төлөвлөж байна. Үүнд, үзэсгэлэнд оролцож буй орос зохиолчдын шинэ номны танилцуулга, уулзалт, видео хөтөлбөр зэрэг багтаж байгаа юм. Дашрамд дурьдахад та бүхэн манай асарт саатан өөрт таалагдсан номыг сонгон авч тухтай үзэх боломжтой. Орос зохиолчдын илтгэлийг та бүхэн зөвхөн манай асар төдийгүй, Номын баярын их тайз мөн Оросын шинжлэх ухаан соёлын төвд болох уулзалтаас сонсох боломжтой. Түүнчлэн бид Улаанбаатар хотын их дээд сургуулиудын оюутнуудад зориулан “ХХ зууны оросын утга зохиол, үндэсний соёлыг түгээн дэлгэрүүлэхэд шинэ медиа хэрэгслэлийн үүрэг ач холбогдол” хэмээх сэдвээр хоёр удаа лекц унших төлөвлөгөөтэй байна. Мөн Монголын хэвлэл мэдээллийн төлөөлөгчидтэй уулзан ярилцлага өгөхөөр төлөвлөж байна.

“Орос гэр” асрын зохион байгуулагчаар, ОХУ-ын Тоон систем, Харилцаа холбоо, Хэвлэл мэдээллийн Хөгжлийн Яамны дэмжлэгтэйгээр ОХУ-ын Орчуулгын хүрээлэн ажиллаж байна. ОХУ-ын Орчуулгын хүрээлэнгийн үйл ажиллагааг оросын уран зохиолыг монгол хэлнээ хөрвүүлэх ажилд тууштай нь оролцож байгаагаар нь Монгол улсад сайн мэдэх билээ.

Тус баярт танилцуулагдах орос хэл дээрх 300 гаруй номыг баяр дууссаны дараа ОХУ-ын Элчин сайдын яам, Оросын шинжлэх ухаан соёлын төвд бэлэг болгон шилжүүлэх юм. Орос хэл сурч байгаа монголын залуучууд болон оросын утга зохиолыг сонирхогч хэн бүхэн “Русский дом в Улан-Баторе” буюу Оросын шинжлэх ухаан соёлын төвийн номын сангийн хамгийн хүндэт зочид байх болно.